



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/221

Номгон

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын
зэрэгт шилжсэн хугацааг сунгаж, коронавируст
халдварын тархалтын “Улаан түвшин”-д
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Коронавируст халдварын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2.1.4, 4.4, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/215, А/216 дугаар захирамж, Улсын Онцгой комиссын 2021 оны 10, аймгийн Онцгой комиссын 2021 оны 31 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын тохиолдол тус аймагт илэрч, батлагдсантай холбогдуулан иргэд, олон нийтийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 24:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 24:00 цаг хүртэл сунгаж, дээрх хугацаанд аймгийн хэмжээнд халдварын тархалтын “Улаан” түвшинд шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж, халдварын тархалтын “Улаан” түвшинд шилжсэнтэй холбогдуулан дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.


2.1. Дээрх хугацаанд аймаг руу орох, гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, тус аймгаас Улаанбаатар хот руу эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах ажлаар зорчих иргэдийг нийслэлийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, Улаанбаатар хот болон бусад аймгуудаас тус аймагт эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун, өвс тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах ажлаар зорчих иргэдийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, аймаг дотор (өөрийн аймгийн сум хооронд) зорчих иргэдийг сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр тус тус нэвтрүүлэх, шаардлагагүй тохиолдолд

1 10555

Улаанбаатар хот болон халдварын тархалтын “Шар”, “Улбар шар”, “Улаан” түвшин бүхий аймгуудаас иргэдийг татан авахгүй байхыг Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

2.2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд үйл ажиллагаа явуулах байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 28-ны өдрийн
А/221 дүгээр захирамжийн
а хангамж

**ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН
ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ХУГАЦААНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ**

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага;
3. Шатахуун, түлшний хангамж;
4. Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, сав баглаа боодол;
5. Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, цуглуулалт, тээвэрлэлт;
6. Улсын бүртгэл болон банкны салбарын үйл ажиллагааг ажлын тусгай горимоор (10:00-14:00 цаг) ажиллуулах;
7. Газар тариалан, өвс тэжээл, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа;
8. Харилцаа холбоо, шуудан илгээмж;
9. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа (эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр);
10. Хэвлэл мэдээлэл;
11. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага;
12. Буяны үйл ажиллагаа.

-----oOo-----